

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форумын “Төрийн бус байгууллагын мониторинг” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Төв аймаг дахь салбараас “Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах” тухай Төсвийн тухай хуулийн 63-р зүйлийн хэрэгжилтэд мониторинг хийллээ. Мониторингийг 2013 оны 10-р сараас 2014 оны 4-р сарын хооронд Төв аймгийн Батсүмбэр, Баяндэлгэр болон Баянчандмань суманд баримт бичгийн судалгаа, санал асуулга ба ярилцлагын аргыг ашиглан хэрэгжүүлсэн юм. Ингэхдээ Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар баталсан Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх Орон нутгийн төсөв боловсруулах журмын “төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах” тухай зүйл дээрх гурван суманд 2012, 2013 онд хэрхэн хэрэгжсэн талаар мэдээлэл цуглуулан, дун шинжилгээ хийсэн юм. Мониторингийн зарим дүнгээс дор толилуулж байна.

МОНИТОРИНГИЙН ДҮН

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 63.1 ДЭХ ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ:

- Олон нийтийн нээлттэй санал асуулгыг бүлгийн ярилцлагаар, асуулгын хуудсаар болон цахим хэлбэрээр авахаар журамласан ч мониторингод хамрагдсан гурван суманд эдгээр аргуудыг ашиглан иргэдийн саналыг авах ажил хангалтгүй байна.

Тухайлбал, 2012 онд Батсүмбэр суманд асуулгын хуудас болон цахим хэлбэр ашиглан насанд хүрсэн иргэдийн 17 орчим хувиас нь санал авсан байна. Баяндэлгэр суманд олон нийтийн саналыг цахим хэлбэрээр авсан бөгөөд санал асуулгад иргэдийн зөвхөн 2 хувь нь хамрагджээ. Харин Баянчандмань суманд нээлттэй санал асуулга огт явуулаагүй бөгөөд хуулийн 63.2-т заасан багийн иргэдийн Нийтийн Хуралд оролцогдоос саналыг нь авсан байна. 2012 онд Орон нутгийн төсөв боловсруулах журмын хэрэгжилт ийнхүү хангалтгүй байсанд тус журам он дуусч байхад буюу 11-р сард батлагдсан нь нөлөөлсөн юм.

2013 онд Баяндэлгэр болон Батсүмбэр сумын багийн Засаг дарга нар олон нийтийн нээлттэй санал асуулга явуулахдаа журамд заасан санал асуулгын гурван хэлбэрийг ашигласан бөгөөд санал асуулгад оролцсон иргэдийн тоо тус бүр ойролцоогоор 80 ба 30 хувиар нэмэгдсэн юм. Харин Баянчандмань суманд иргэдийн саналыг цахим хэлбэрээр авч, насанд хүрсэн иргэдийн 0.5 орчим хувийг хамруулжээ.

63.1. Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.


ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 63.2 ДАХЬ ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ:

- Төсвийн тухай хуулийн 63.1-д заасан нээлттэй санал асуулга болон 63.2-т заасан багийн иргэдийн Нийтийн Хурлын үеэр саналаа илэрхийлэх замаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг тодорхойлох явцад иргэдийн оролцоо хангалтгүй байна:





**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл,
арга хэмжээний талаарх саналаа өгсөн иргэдийн хуваарь**




63.2. Энэ хуулийн
63.1-д заасан санал
болон баг, хорооны
иргэдийн Нийтийн
Хурал дээр гарсан
саналыг иргэдийн
Нийтийн Хурал
хэлэлцэн, тэргүүлэх ач
холбогдол бүхий төсөл,
арга хэмжээг эрэмбэлэн
сонгоно.

- Орон нутгийн төсөвт иргэдийн оролцоо төдийлөн сайнгүй байгааг дараах шалтгаанаар тайлбарлаж болно:

- нээлттэй санал асуулгын хэлбэрүүдийг, ялангуяа айл өрх бүрийг хамарч чадах асуулгын хуудасны аргыг бүрэн ашиглахгүй байгаа;
- иргэдийн саналыг зөвхөн 63.2-т заасан багийн иргэдийн Нийтийн Хуралд оролцогдоос авч байгаа;
- орон нутгийн хөгжлийн сан болон түүнийг зарцуулахад иргэд хэрхэн оролцох боломжтой тухай мэдээллийг олон нийтэд түгээх ажил хангалтгүй байгаа. Тухайлбал, 2012 онд саналаа өгөөгүй гэж хариулсан Батсүмбэр, Баяндэлгэр болон Баянчандмань сумын 400 орчим хүнээс оролцоогүй шалтгааныг нь асуухад дараах тайлбар өгчээ:

**Та орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
хэрэгжүүлэх ажлуудын талаар саналаа яагаад өгөөгүй вэ?**



- Санал асуулга явагдаж байгааг дуулаагүй
- Ач холбогдлыг ойлгоогүй
- Алс нутаглаж байсан
- Бусад

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг тодорхойлох багийн иргэдийн Нийтийн Хурлын өмнө болон хурлын явцад багийн Засаг дарга дараах мэдээллийг иргэдэд хүргэх ёстой боловч энэ үүргээ хангалтгүй гүйцэтгэж байна:

- Иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 2 долоо хоногийн өмнө багт 1) тухайн суманд хуваарилагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо, 2) иргэдээс гарсан урьдчилсан жагсаалт, 3) сумын Засаг даргаас ирүүлсэн тухайн сум, багт хэрэгжүүлэх шаардлагатай хөгжлийн бодлого чиглэлтэй уялдсан төслүүдийн мэдээлэл, 4) өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний товч мэдээллийг байршуулах ёстой боловч мониторингод хамруулсан 3 сумын багийн Засаг дарга нар эдгээр мэдээллийг цаг хугацаанд нь, бүрэн гүйцэд байршуулаагүй байна.



Тухайлбал, 2013 онд багийн Засаг дарга дээрх дөрвөн төрлийн мэдээллээс зөвхөн хоёрыг нь бэлтгэж, иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 1-3 хоногийн өмнө багт байршуулжээ.

- Иргэдийн Нийтийн Хурлын үеэр 1) иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, 2) сумын Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал, 3) хурлын үеэр иргэдийн дэвшүүлсэн саналыг хэлэлцүүлэх шаардлагатай боловч хөгжлийн бодлоготой уялдсан төслийн саналыг З сумын аль ч багт хэлэлцээгүй байна.
- Ийнхүү орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг эрэмбэлэн сонгоход шаардагдах мэдээллээр иргэдийг тухай бүр, бүрэн гүйцэд хангахгүй байгаа учраас багийн иргэдийн Нийтийн Хуралд үр дүнтэй оролцож, оновчтой шийдвэр гаргах боломж иргэдийн хувьд хязгаарлагдмал байна. Тухайлбал, Баянчандмань сумын Эрдэнэ багийн иргэдийн Нийтийн Хуралд оролцогчид өмнөх жилүүдэд хэрэгжсэн, эсвэл орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр хориглосон төсөл, хөтөлбөрийг санал болгож¹, хоорондоо маргалдах, улмаар хурлын дэгийг зөрчих явдал гарч байлаа. Түүнчлэн, мониторингод хамруулсан гурван сумын багуудад иргэдийн Нийтийн Хурлын үеэр орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр санал болгож байсан төсөл, хөтөлбөрүүд тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдахгүй байх явдал гарч байлаа.

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 63.3 ДАХЬ ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ:

- Сумын Засаг даргын Тамгын газар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсвийн төсөл боловсруулахдаа арга зүйн зөвлөмж өгч, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах ёстой боловч ажлын хэсэг байгуулахгүй, төслийн нэгдсэн жагсаалтыг батлагдсан маягтын дагуу бэлтгэхгүй байх явдал гарч байна. Үүний улмаас сумын Засаг даргын Тамгын газраас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж буй санал нь шаардлага хангахгүй байна. Жишээлбэл, Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас 2014 оны орон нутгийн хөгжийн сангаас хэрэгжүүлэх төслийн саналын төсвийн тооцоо алдаатай байснаас иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төслийн жагсаалтыг засаж сайжруулахаар сумын Засаг даргын Тамгын газарт буцааж байжээ.

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 63.4 ДЭХ ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ:

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2012 онд орон нутгийн хөгжлийн сангаас Батсүмбэр суманд 249,300,000 төгрөгийн өртөгтэй 11, Баяндэлгэр суманд 159,200,000 төгрөгийн өртөгтэй 9, Баянчандмань суманд 150,300,000 төгрөгийн өртөгтэй 9 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр тус тус баталжээ.
- 2013 онд орон нутгийн хөгжлийн сангаас Батсүмбэр суманд 291,993,000 төгрөгийн өртөгтэй 12, Баяндэлгэр суманд 199,397,200 төгрөгийн өртөгтэй 11, Баянчандмань суманд 188,242,100 төгрөгийн өртөгтэй 11 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр тухай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан байна.

¹ Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргэс бусад хөтөлбөр, арга хэмжээ; улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага; үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал; нийтийн эрх ашигт нийзээгүй үйл ахиллагаа; зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах; орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төвлөлөгөөнд тусгах батлаагүй зардал, арга хэмжээ (Төсвийн тухай хуулийн 60.3-р заалт)

63.3. Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

63.4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Шинээр эхлэн гаргаж буйэнэхүү цувралаар Төрийн Бус Байгууллага (ТББ)-уудын төрийн үйлчилгээндхийж байгаа Мониторингийн гол дүнг хүргэх юм. Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйзэр хийгддэг ТББ-уудын мониторингоор төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдал амьдралдхэр бодитой хэрэгжиж байгааг баримтаар баталгаажуулж дүгнэлт, зөвлөмж гаргадаг билээ. Мониторингийн үр дүнт олон нийтэд хүргэхийн сацуу төрийн үйлчилгээг цаашид боловсронгуй болгох чиглэлээр мониторинг хийсэн зарим ТББ-ууд нөлөөллийн үйл ахиллагаа явуулдаг юм.